МЭДЭЭ · 2020 оны 3-р сарын 19

ОНЦГОЙ НӨХЦӨЛД АЖИЛЛАЖ БАЙГАА АЛБАН ХААГЧДАД ХАЛУУН ХООЛ, ААРЦААР ҮЙЛЧИЛЖЭЭ



Улсын Онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоол, Говьсүмбэр аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэрээр шинэ төрлийн коронавирусын /Covid-2019/ халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, сумын төвөөс тээврийн хэрэгслээр орох, гарах хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 07:00 цаг хүртэл хааж, пост ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Говьсүмбэр аймгийн прокурорын газрын хамт олон нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр Шивээ-Овоо, Сүмбэр, Баянтал сумын пост дээр ажиллаж байгаа эмнэлэг, цагдаа, мэргэжлийн хяналтын газрын албан хаагч нарт халуун хоол, аарцаар үйлчилжээ.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3068